



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 11/21

Шивээговь сум

“Хог тээвэрлэх автомашин худалдан авах”
тоног төхөөрөмжийг хүлээн авах
комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, 14 дүгээр зүйлийн 14.2.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн “Хог тээвэрлэх автомашин худалдан авах” тоног төхөөрөмжийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Баасанбат (Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	З.Баасандалай (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Түвшинжаргал (Нягтлан бодогч) Д.Эрдэнээ (Нярав) Г.Мөнхжаргал (Хогны машины жолооч)
Нийлүүлэгчийг төлөөлж:	Т.Отгоншагай (“Харвайн толгой” ХХК-ийн Ерөнхий инженер)

2. “Хог тээвэрлэх автомашин худалдан авах” тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын түвшинд хүлээн авах комиссын дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

4212 193